



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар A/186

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.19, 23.2.21 дэх заалт, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2.Аргачлалыг бүх ангиллын газарт мониторинг хийх үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг мэргэжлийн байгууллагуудад, хэрэгжилтийг хангаж ажиллахыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын газрын даамал нарт тус тус үүрэг болгосугай.

3.Арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Газрын мониторингийн хэлтэс (Б.Дөл)-т даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА  А.ЭНХМАНЛАЙ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ  
1525010978  
ЭХ ХУВЬ  
Захиргааны акт №  
дугаар A/186



Газар зохион байгуулалт, геодези,  
зураг зүйн өрөнхий газрын даргын 2025  
оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн  
11:00 дугаар тушаалын хавсралт

## ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ЦЭГИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ШААРДЛАГА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (цаашид “газрын хянан баталгаа” гэх)-г хийх зориулалттай байнгын ажиллагаатай газрын мониторингийн сүлжээний цэг (цаашид “газрын мониторингийн цэг” гэх)-ийг өтгөрүүлэх, шинээр байгуулахад энэхүү аргачлалыг дагаж мөрдөнө.

1.2. Газар бол хүрээлэн буй орчны хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд орон зайд, газрын гадаргын, газрын хэвлэлий, хөрс, ургамлан бүрхэвч, цаг уурын үзэгдлийг өөртөө агуулдаг. Төрөөс газрын ашиглалт, бохирдол, доройтлыг тодорхойлох түүнд тохирсон арга хэмжээ авах зорилгоор газрын мониторингийн цэг, түүний нэгдсэн сүлжээгээр дамжуулан газрын мониторингийн үйл ажиллагааг эрхэлнэ.

1.3. Газарт төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын нэгдмэл сангийн төлөв байдлыг ажиглах, түүний өөрчлөлтийг цаг алдалгүй илрүүлэх, үнэлгээ өгөх, сөрөг үзэгдэл, үйл явцад урьдчилан дүн шинжилгээ хийх, бууруулах чиглэлээр газрын мониторингийн цэгийн үйл ажиллагааг зохион байгуулна.

1.4. Газрын мониторингийн цэгийн өгөгдөл мэдээллийг газрын бодлогын түвшинд дараах үйл ажиллагаанд хэрэглэнэ.

- Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан газрын бодлогыг хэрэгжүүлэх;
- Газрын нэгдмэл сангийн төрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтад;
- Тухайлсан газрын төлөв байдал, чанарыг харгалзан газар ашиглалтыг төлөвлөх;
- Газрыг үр ашигтай ашиглах, хамгаалах;
- Газрын төлөв байдал, чанарт болон тохиромжтой байдлын үнэлгээ хийх;
- Газрын нэгдмэл сан, газрын цогц мэдээллээр хэрэглэгчдийг хангах.

1.5. Газрын мониторингийн сүлжээ (цаашид “мониторингийн сүлжээ” гэх)-ний мэдээллийг газрын төлөв байдал, чанарын мэдээллээр тогтмол, тогтвортой шинэчлэн баяжуулж, газар ашиглалттай холбоотой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглана.

1.6. Газрын нэгдмэл сангийн ангиллын бүх газарт газрын мониторингийн цэгийг энэхүү аргачлалын дагуу байгуулна.

1.7. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газрууд тэдгээрийн газар ашиглалтын байдлаас үл хамааран засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрд газрын мониторингийн цэгт ажиглалт, хэмжилтийг хийж, мэдээллийг боловсруулж, газрын мониторингийн цахим системээр дамжуулан хэрэглээнд гаргана.

### **Хоёр. Газрын мониторингийн цэгийн төрөл**

2.1. Газрын төлөв байдлын өөрчлөлт түүнд нөлөөлөгч хүчин зүйл, судалж байгаа үндэслэлээс шалтгаалж газрын мониторингийн цэгийг суурь (хяналтын) мониторингийн цэг, нөлөөллийн (бохирдлын) мониторингийн цэг гэж 2 ангилана.

2.2. Суурь мониторингийн цэг нь хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газрыг байгалийн үндсэн нөхцөл, түүний хувьсал өөрчлөлтийг ажиглаж, судлан тогтоож тухайн бүс нутгийн нөлөөлөлд өртсөн газартай харьцуулан жишиж доройтлыг тогтоох зорилготойгоор байгуулна.

2.3. Нөлөөллийн мониторингийн цэгийг байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн газрын төлөв байдал, чанарыг тогтоох зорилготойгоор байгуулна.

2.4. Газар ашиглалтын нөлөө, хүрээлэн буй орчны чанарыг тодорхойлоход газрын мониторингийн цэгийг байршлыг зөв сонгон байгуулж, түүний хэмжилт шинжилгээний үндсэн дээр тухайн газрын нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв илрүүлэн таних зорилготойгоор судалгаа шинжилгээг хийж гүйцэтгэнэ.

2.5. Газар ашиглалтын сөрөг үйлдэл нь орчны доройтлын хэлбэрээр илэрдэг бөгөөд доройтол нь суурь мониторингийн цэг болон нөлөөллийн мониторингийн цэгүүдийн тогтвортой үндсэн үзүүлэлтийг харьцуулна. Тухайн хоёр мониторингийн цэгүүдийн мэдээлэл нь тогтмол нэг цаг хугацаанд харьцуулагдаж байж тухайн газрын төлөв байдал бодитой тодорхойлогдоно.

### **Гурав. Газрын мониторингийн цэгийг өтгөрүүлэх, нэмж байгуулах үндэслэл, шаардлага**

3.1. Газрын мониторингийн цэгийг дараах газар нутагт өтгөрүүлэх, шинээр байгуулах хэрэгцээ шаардлагатай. Үүнд :

- Хүн амын төвлөрөл, нягтрал ихтэй газарт;
- Малын тоо толгой өссөн болон бэлчээрийн талбай багассан газарт;
- Буруу технологи ашиглаж хөрсийг доройтуулсан тариалангийн газарт;
- Үйлдвэржилтийн улмаас байгаль орчинд сэргөөр нөлөөлж элэгдэл эвдрэлд орж, бохирдолд өртсөн газарт;
- Байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд өөрчлөлт орж буй газар болон цөлжилт эрчимтэй явагдаж буй газарт;
- Экологийн тэнцвэрт байдал алдагдсан, үйлдвэрийн ослын улмаас хохирол учирсан газарт;

-Газрын мониторингийн цэг нь нийт тухайн нутаг дэвсгэрийг бүхэлд нь жигд хамраагүй, бүрэн төлөөлөх чадваргүй нөхцөлтэй газарт.

3.2. Газрын мониторингийн цэгүүдийг өтгөрүүлэх, нэмж байгуулахад дараах үндэслэлийг баримтална. Үүнд:

3.2.1. Шинээр нэмж байгуулах газрын мониторингийн цэг нь “Монгол орны байгаль-нутаг цогцолбор нөхцөлийн мужлал”-ын 3 бүс, 12 муж, 31 тойрог тус бүрийг төлөөлж байх шалгуурыг хангасан байх шаардлагатай. Тухайн сум орон нутагт одоо байгаа газрын мониторингийн цэг нь байгаль-нутаг дэвсгэрийн бүс, муж, тойргийг төлөөлөөгүй байвал шинээр цэг сонгох гол үндэслэл болно.

### Хүснэгт 1. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлал.

№	Бүс	Мужийн нэр	Тойргийн нэр
1	Хангайн бүс	Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж	Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрог (Х-1)
2			Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрог (Х-2)
3		Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж	Хангийн нурууны ойт хээр бүхий тойрог (Х-3)
4			Булнай-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог (Х-4)
5			Хангайн тэгш өндөрлөгийн тойрог (Х-5)
6		Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж	Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог (Х-6)
7			Сэлэнгэ-Орхоны хөндийн хээр бүхий тойрог (Х-7)
8		Хэнтийн нурууны тайга зонхилсон муж	Хэнтийн төв хэсгийн тайгын тойрог (Х-8)
9			Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог (Х-9)
10			Улз голын савын ойт хээр, хээрийн тойрог (Х-10)
11		Монгол-Алтайн өндөр уулын муж	Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог (Х-11)
12			Алтай Таван богдын өндөр уулын тойрог (Х-12)
13			Мөнххайрханы өндөр уулын тойрог (Х-13)
14			Хар азрага-Гичгэний нурууны өндөр уулын тойрог (Х-14)
15		Хянганы салбар уулсын муж	Дэгээ-Нэмрөг голын савын дундаж уулсын тойрог (Х-15)
16	Говийн бүс	Алтайн ар.govийн цөлөрхөг муж	Увс нуурын хотгорын тойрог (Г-1)
17			Хяргас нуурын хотгорын тойрог (Г-2)
18			Алтайн нурууны салбар уулс, хотгорын тойрог (Г-3)
19			Нууруудын хөндийн тойрог (Г-4)
20		Говийн Алтайн уулсын муж	Их, Бага Богдын уулсын тойрог (Г-5)
21			Гурван сайханы уулсын тойрог (Г-6)
22			Баруун хуурайн хотгорын тойрог (Г-7)
23		Алтайн өвөр говийн цөлийн муж	Алтайн өвөр говийн тойрог (Г-8)

24	Тал хээрийн бүс	Дорнод говийн цөлөрхөг муж	Дорнод говийн хойт хэсгийн тойрог (Г-9)
25			Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)
26		Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн муж	Дундад халхын тэгш өндөрлөгийн тойрог (Т-1)
27			Хэрлэн голын хойт Хөх нуур орчмын тойрог (Т-2)
28			Хэрлэн голын өмнөд Баруун уртын нам уулсын тойрог (Т-3)
29			Мэнэнгийн тэгш талын тойрог (Т-4)
30		Дорнод монголын цав толгодлог нам уулс бүхий хээрийн муж	Дарьгангын тэгш өндөрлөгийн тойрог (Т-5)
31			Эрдэнэцагааны нам уулсын тойрог (Т-6)

3.2.2. Газрын мониторингийн шинээр нэмж байгуулах цэг нь хөрс-ургамлан нэмрэгийн хэвшинж, тэдгээрийн төлөв байдлыг төлөөлөхүйц байна. Тухайн сум, дүүргийн газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг болон хөрс-ургамлын хэвшинжийг одоо байгаа газрын мониторингийн цэг болон фото мониторингийн цэг нь бүрэн төлөөлж байгаа эсэхийг шалгана. Хэрэв хөрс-ургамлын хэв шинжийг төлөөлж чадахгүй байвал шинээр мониторингийн цэг сонгох үндэслэл болно.

#### Хүснэгт 2. Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвар.

Бүс, бүслүүр	Бэлчээрийн экологийн бүлэг	Зонхилох бүлгэмдлийн нэр
Ойт хээрийн бүс	Уул, толгодын орой, хажуу	Чулуурхаг хөрстэй чулуулаг алаг өвс-үетэнт
	Уулын бэл, хөндий, уулын нуга	Шавранцар хөрстэй алаг өвс- жижиг дэгнүүлт үетэнт
		Шавранцар хөрстэй улалж- үетэн-алаг өвст
		Шавранцар хөрстэй алаг өвс- үетэнт
	Голын татам	Аллювиийн хөрстэй алаг өвс- үетэнт
Хуурай хээрийн бүс	Уул, толгодын орой, хажуу, бэл	Чулуурхаг хөрстэй алаг-өвс-жижиг дэгнүүлт үетэнт
		Хөнгөн шавранцар хөрстэй үетэн-хялганат
	Гүвээт тал	Элсэнцэр хөрстэй Харгана бүхий Үетэн-хялганат
	Тэгш тал	Элсэнцэр хөрстэй алаг өвс-үетэн-хялганат
	Нам хотос	Элсэнцэр хөрстэй Дэрст
Цөлөрхөг хээрийн бүс	Нам уулс, толгод	Хайрга чулуурхаг хөрстэй Сөөгөнцөр- Монгол өвст
		Элсэнцэр хөрстэй Сөөгөнцөр- таана- үетэнт
		Мараалаг шавранцар хөрстэй Таана- сөөгөнцөр- Монгол өвст
	Нам хотос	Хужир мараалаг хөрстэй бударгана- дэрст
	Хагас бэхэжсэн элс	Элс хөрстэй Үетэн- алаг өвст, сульт
Цөлийн бүс	Уул, толгод	Хайрга чулуурхаг Баглуурт, баглуур-шар модот
	Нам хотос	Давсархаг хөрстэй Сөөгөнцөрт
	Хагас бэхэжсэн элст	Загт, Заг – алаг өвст
		Заг- хармагт

Өндөр уулын бүслүүр	Уулын таг	Жижиг дэгнүүлт үетэн- хүйтсэг алаг өвст
	Уулын хээр	Хүйтсэг алаг өвс- ботуульт
	Уулын нуга	Сөөг бүхий алаг өвс- том дэгнүүлт үетэнт

3.2.3. Газрын мониторингийн цэг нь сум, дүүргийн нийт нутаг дэвсгэрт одоо байгаа газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллыг бүрэн төлөөлж байх ёстой. Тухайн сум, дүүргийн газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал тус бүрийг мониторингийн цэг нь төлөөлж чадахгүй байвал шинээр мониторингийн цэг сонгох үндэслэл болно.

3.2.4. Сум, дүүргийн нийт нутаг дэвсгэрт газрын мониторингийн цэгийн газарзүйн байршил нь нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд тархсан байх шаардлагатай. Сум, дүүрэг, баг, хорооны хил доторх газрын мониторингийн цэгт дүн шинжилгээ хийж жигд тархсан эсэхийг шалгаж үзнэ.

#### **Дөрөв. Мониторингийн ажиглалтын талбар сонгох шалгуур**

4.1. Газрын мониторингийн цэг нь судалгаа шинжилгээ хийх ажиглалтын талбарыг бүрэн төлөөлж байх ёстой.

4.2. Ажиглалтын талбар сонгох шалгуур нь заавал мөрдөх шалгуур, харгалзан үзэх шалгуур гэсэн 2 шалгуураас бүрдэнэ.

4.3. Заавал мөрдөх шалгуур нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх, газар ашиглалтыг төлөөлөх, ургамлан нөмрөгийг төлөөлөх, судалгаа шинжилгээ хийхээр очиход хүндрэл багатай байх, хөрсөн бүрхэвчийг төлөөлөх, холбогдох төлөвлөлтүүдтэй уялдах гэсэн дараах шалгууруудыг хангаж байх шаардлагатай байна. Үүнд:

4.3.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх чадвар нь тухайн ажиглалтын талбар нь нутаг дэвсгэрт бүрэн харьяалагдаж байх ёстой.

4.3.2. Газар ашиглалтыг төлөөлөх нь газрын бүрхэвч, барилгын нягтшил, газар ашиглалтын зориулалт, газрын нэгдмэл сангийн дэд ангиллыг бүрэн төлөөлсөн байх ёстой.

4.3.3. Ургамлан нөмрөгийг төлөөлөх гэдэг нь тухайн сум, дүүрэг дэх ургамлын хэв шинж болон тухайн бүс нутгийн ургамлын үндсэн хэв шинжийг төлөөлөхүйц байх ёстой.

4.3.4. Судалгаа шинжилгээ хийхээр очиход хүндрэл багатай байх гэдэг нь авто машинаар ажиглалтын талбар болон мониторингийн цэгт саадгүй хүрдэг байхаар төлөвлөх. Зөвхөн ердийн хөсөг болон явганаар хүрэх боломжтой саад ихтэй байршилд ажиглалтын талбар байгуулахаас зайлсхийх хэрэгтэй.

4.3.5 Хөрсөн бүрхэвчийг төлөөлөх гэдэг нь тухайн сум, дүүрэг дэх хөрсний үндсэн хэв шинж болон тухайн бүс нутгийн дэд хэв шинжийг төлөөлөхүйц байх ёстой.

4.3.6 Холбогдох төлөвлөлтүүдтэй уялдах гэдэг нь Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бусад салбаруудын төлөвлөгөөнд ирээдүйд газар ашиглалтын зориулалтыг өөрчлөх, бүтээн байгуулалт хийхээр тусгагдсан газруудад мониторингийн цэгийг байгуулахгүй.

4.4.Харгалзан үзэх шалгуурт талбайн хувьд хангалттай байх, доройтолд ороогүй байх эсвэл газрын доройтлын төрлийг төлөөлөхүйц, суурь мэдээлэл бүрдсэн байх, төлөвлөгөөт хянан баталгаанд хамрагдсан байх, газрын гадаргуугийн хэлбэрийг харгалзан үзсэн байх гэсэн шалгуурууд орно.

4.4.1.Талбайн хувьд хангалттай байх гэдэг нь ажиглалтын талбар хамгийн багадаа 5 га-аас багагүй байх бөгөөд нөлөөллийн мониторингийн цэгээс хөрсний дээж авахад төлөөлөх чанарт нөлөө үзүүлэхгүй байх шаардлагатай. Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллын газрууд, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон томоохон хэмжээний газруудад мониторингийн ажиглалтын талбарыг тогтоохдоо зургийн масштабаас хамааран хэр хэмжээтэй байгуулж болохыг тогтооно. Харин зургийн масштаб газрын ангиллаас хамааран ажиглалтын талбарын талбайн хэмжээ харилцан адилгүй байж болно.

### Хүснэгт 3. Ажиглалтын талбарын жишиг талбайн хэмжээ.

№	Ажиглалтын талбар байгуулах газрууд		Зургийн масштаб	Талбарын хамгийн бага жишиг
1	Хөдөө аж ахуйн газар	ХАА-н барилга, байгууламжийн газар	1:1 000- 1:10 000	5-30
2	Хот, тосгон, бусад суурины газар	Уурхайн нөөц газраас бусад Уул уурхайн газарт		
3	Хот, тосгон, бусад суурины газар	Барилга байгууламжийн газар		
4	Хот, тосгон, бусад суурины газар	Суурьшлын газар		
5	Хот, тосгон, бусад суурины газар	Үйлдвэрийн газар		
6	Хот, тосгон, бусад суурины газар	Нийтийн эдэлбэрийн газар		
7	Хот, тосгон, бусад суурины газар	Амралт, аялал жуулчлалын газар		
8	Хот, тосгон, бусад суурины газар	Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн		

9	Хот, тосгон, бусад суурины газар	Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн		
10	Хот, тосгон, бусад суурины газар	Цаашид тэлж хөгжих нөөц газар		
11	Хөдөө аж ахуйн газар	Хадлан		
12	Хөдөө аж ахуйн газар	Усалгаатай тариалан		
13	Хөдөө аж ахуйн газар	Усалгаагүй тариалан		
14	Хөдөө аж ахуйн газар	Атаршсан газар	1: 25 000-50 000	30-60
15	Хөдөө аж ахуйн газар	Ашиглахад тохиромжгүй газар		
16	Хот, тосгон, бусад суурины газар	Уурхайн газар		
17	Хот, тосгон, бусад суурины газар	Уул уурхайн газрын Уурхайн нөөц газар		
18	Хөдөө аж ахуйн газар	Бэлчээр		
19	Зам, шугам сүлжээний газар	Төмөр замын газар		
20	Зам, шугам сүлжээний газар	Авто замын газар		
21	Зам, шугам сүлжээний газар	Агаарын тээврийн газар		
22	Зам, шугам сүлжээний газар	Шугам сүлжээний газар		
23	Зам, шугам сүлжээний газар	Усан тээврийн газар	1:100 000- 1: 200 000	60-с их
24	Ойн сан бүхий газар	Ойн сан бүхий газар		
25	Ойн сан бүхий газар	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар		
26	Усны сан бүхий газар	Булаг, шанд		
27	Усны сан бүхий газар	Нуур, цөөрөм, тойром		
28	Усны сан бүхий газар	Мөнх цас, мөсөн гол		
29	Усны сан бүхий газар	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс		

4.4.2.Доройтолд ороогүй байх гэдэг нь тухайн газрын экосистем унаган төрхөө алдаагүй байх болон хүний үйл ажиллагаанд маш бага өртсөн байх шалгуурыг хангасан байх. Эсвэл газрын доройтлын төрлийг төлөөлөхүйц гэдэг нь мониторингийн ажиглалтын талбар нь тодорхой нэг аж ахуйн нөлөөлөл, газрын доройтлыг бүрэн төлөөлөхүйц байна.

4.4.3.Суурь мэдээлэл бүрдсэн байх гэдэгт тухайн ажиглалтын талбарын цаг уур, ус зүй, хөрс, геологи, амьтан, ургамлын талаарх тодорхой хэмжээний мэдээлэл бүрдсэн байхыг хэлнэ.

4.4.4.Төлөвлөгөөт хянан баталгаанд хамрагдсан байх гэдэгт төлөвлөж байгаа газрын мониторингийн цэг болон ажиглалтын талбар нь өмнө хийгдсэн газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаанд хамрагдсан эсэхийг шалган үзнэ.

4.4.5.Газрын гадаргуугийн хэлбэрийг харгалzan үзсэн байх гэдэг нь байгалийн тогтоц, бүс бүслүүрийн хил заагтай уялдсан байх ёстой. Үүнд:

-Газрын хотгор гүдгэр буюу рельеф. Газрын хотгор гүдгэр нь ажиглалтын талбар, мониторингийн цэгийн орон зайн тархалтын гол нөхцөл бөгөөд байр зүйн зургийн үндсэн элементүүд, өндөржилтийг харгалzan үзнэ.

-Геологийн тогтоц. Хурдас чулуулгийн илэрц буюу хад, нуранги хад зэрэг элементүүдийг үндэслэн ажиглалтын талбарын байгалийн хил заагийг тодорхойлох боломжтой бөгөөд өндөр уулын бүс, сул элс, элсэн манхан, цав толгод, геологийн тогтоц нь талбарыг тогтоох гол үзүүлэлт болдог.

-Хүний үйл ажиллагаа. Барилгажсан газар, үйлдвэрийн газар, суурин газрын хил зааг, хадлан, тариалан, уст цэг, зам, хот суурины хил заагийг зайнаас тандан судалгааны аргаар тогтоох болон газар ашиглалтын төрлүүд, гадаргуугийн талхагдал зэргийг үндэслэх нь ажиглалтын талбарын хилийг тогтоох чухал үзүүлэлтүүд болно.

4.5.Ажиглалтын талбаруудыг өмнө хийгдсэн газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгаа, кадастрын мэдээллийн сан, газрын нэгдмэл сангийн дэд ангилал болон хиймэл дагуулын мэдээг ашиглан хил заагийг тодорхойлж зурж байгуулна. Хот, тосгон, бусад суурины газарт ажиглалтын талбарыг дотор нь газар ашиглалтын зориулалтаар нь холимог барилгажсан (өндөр, дунд давхрын орон сууц, үйлдвэр үйлчилгээ, төрийн захиргаа), орон сууцны, нам давхрын суурьшлын газар (гэр хороолол), үйлдвэрийн газар, нийтийн эдэлбэрийн газраар нь ангилан байгуулна.


4.6.Ажиглалтын талбарт гаднын нөлөөгөөр үүсэж бий болсон хөрсний зулгаралт, бохирдолт, салхины элэгдэл, усны эвдрэл, элсжилт, гуу жалга, ухсан нүх, овоолго, ургамлан нөмрөгийн доройтол, талхагдал зэрэг гаднын хүчин зүйлсийн нөлөөлөл байвал тухайн хилийг тодорхойлж, нөлөөллийн мониторинг хийх ажиглалтын талбарыг байгуулна.

4.7. Төлөвлөсөн ажиглалтын талбарын хил нь дүрс зүйн хувьд зөв хэлбэр дүрстэй байна. Тухайн ажиглалтын талбарын хил заагийг хурц, олон өнцөгтэй, нарийн зурvas (усны сангийн гол горхины дагуу үүсгэх талбараас бусад тохиолдолд), цоохорлож байгуулахыг хориглоно.

4.8. Ажиглалтын талбар нь газрын гадаргуу, хөрс, ургамлан нэмрөг, орчны төлөв байдлыг бүрэн төлөөлөхүйц, өөрчлөлтийн хамрах хүрээ, хил заагийг тод гаргасан, талбайн хэмжээг зөв тодорхойлсон тохиолдолд мониторингийн цэгийг байгуулна.

#### **Тав. Мониторингийн цэгийн байршлыг төлөвлөх, сонгох шалгуур**

5.1. Газрын мониторингийн цэгийг дараах схемийн дагуу төлөвлөнө.



Диаграм 1.

5.2. Газрын мониторингийн цэгийг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална. Үүнд:

5.2.1. Бэлчээр, хадлангийн газарт: Газрын мониторингийн цэг болон фото мониторингийн цэгийг адил зарчмаар төлөвлөнө. Бэлчээрийн газарт хийгдсэн төлөвлөгөөт хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг болон Монгол орны бэлчээр хадлангийн анги, бүлэг, төрлүүд, хөрсний үндсэн болон дэд хэв шинжийг бүрэн хамарсан эсэхийг шалгаж үзнэ. Бүрэн хамрагдаагүй байгаа газруудыг сонгож мониторингийн цэгийг төлөвлөнө. Тухайн сум, дүүрэгт байх өвөл, хавар, зун, намрын бэлчээр, отрын нөөц нутаг, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр (БАХ, Малчин өрхийн анхдагч холбоо, бүлэг нөхөрлөл, хоршоо) зэрэг төрлүүдийг төлөөлөх мониторингийн цэг байх шаардлагатай. Алслагдсан, бартаа ихтэй, усгүй зэрэг шалтгааны улмаас ашиглалт муу байгаа бэлчээрийн газар болон элсэн манхан, хад асга, шал, сайр зэрэг газар ашиглалтад тохиromжгүй газруудад мониторингийн цэгийг төлөвлөхгүй байх шаардлагатай.

Хадлангийн талбайг ердийн, усалгаатай газраар нь ангилж суурь мэдээлэл, тогтоосон хил заагийг үндэслэн цэг төлөвлөнө.

5.2.2. Тариалангийн болон атаршсан газарт: Тариалангийн талбайг “усалгаатай, усалгаагүй” гэж ангилан таримлынх нь төрлөөр “үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, техникийн ургамал, жимс жимсгэнэ тариалсан талбай” гэж ангилж, ангилал нэг бүрээс төлөөлж байхаар газрын мониторингийн цэгийг төлөвлөнө. Атаршсан газарт суурь мониторингийн цэг байгуулна.

5.2.3. Хот, тосгон, бусад суурины газарт: Төлөвлөгөөт хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг болон Монгол орны бэлчээр хадлангийн анги, бүлэг, төрлүүд, хөрсний үндсэн болон дэд хэв шинж бүрэн хамарсан эсэхийг шалгана. Бүрэн хамрагдаагүй газрын нэгмдэл сангийн дэд ангиллуудад байгуулахаар төлөвлөнө. Орон сууц, гэр хороолол, зуслангийн газар, барилга, байгууламжийн газар, өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдоогүй сул чөлөөтэй газрууд, оршуулгын газар, хог хаягдлын цэг, бусад нийтийн эдэлбэрийн газар, үйлдвэрийн газар гэж ангилж төлөвлөнө. Уурхай, аялал жуулчлал, рашаан сувилал, амралт зугаалгын газарт гэрээгээр болон лицензээр олгогдон ашиглалт, олборлолт явуулж буй талбай, барилга байгууламж, нөөц газраар ангилж тус бүрд мониторингийн цэгийг төлөвлөнө.

5.2.4. Улсын тусгай тусгай хэрэгцээний газарт: Тусгай хэрэгцээний газар нутаг нь газрын бүрхэвчийн болон газар ашиглалтын төрөл бүрийн ангиллаас бүрддэг. Иймд газар ашиглалтын ялгаатай нэгж талбараадад бусад ангиллын газарт цэг төлөвлөх зарчмын дагуу төлөвлөнө. Улсын тусгай хэрэгцээний газарт цэг төлөвлөхдөө үндсэн болон дэд ангиллын газар тус бүрд тандан судалгааны аргаар болон хүний үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн газруудад газрын мониторингийн цэгийг төлөвлөнө. Тусгай хэрэгцээний газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны анхны үзүүлэлтүүд байхгүй тохиолдолд тандан судалгааны аргаар мониторингийн үзүүлэлтийг тодорхойлж болно.

5.2.5. Ойн сан бүхий газарт: Ойн сан бүхий газарт мониторингийн цэгийг хүний үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн газруудад төлөвлөнө. Мөн зайнаас тандан судлалын арга зүйг ашиглан төлөвлөж болно. Ингэхдээ цагаан энгэр зэрэг ойн бус талбайд цэг төлөвлөхгүй. Ойн сан бүхий газарт ордог ой модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, мод үржүүлгийн газарт цэг төлөвлөхгүй. Түймэрт өртсөн ой, ой тэлэн ургах нөөц газарт нөлөөллийн мониторингийн цэг байгуулж тандан судалгааны аргаар мониторинг хийж болно. Ойн тэлэн ургах нөөц газрыг ойн захаас 100 метрийн зйтгэлээр тооцож зураглана.

5.2.6. Усны сан бүхий газарт: Усны сан бүхий газарт байгуулах мониторингийн цэгийг хүний үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн газруудад төлөвлөнө. Мөн зайнаас тандан судлалын арга зүйг ашиглан төлөвлөж болно. Гол, горхины эргээс 200 метрийн зурvas газарт, зөвхөн байнгын тогтмол устай нуур, цөөрөм,

тойрмын эргээс 10 метрийн зйтайгаар, булаг, шандыг 5 метрийн радиустайгаар талбайн хүрээнд хуурай газарт цэг байгуулахаар төлөвлөж болно. Мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газарт газрын мониторингийн цэг төлөвлөхгүй.

5.3. Ажиглалтын талбарт газрын мониторингийн цэгийг төлөвлөхдөө дараах харгалзан үзэх нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг үзнэ. Үүнд:

5.3.1. Газрын мониторингийн цэг нь аль болох тухайн ажиглалтын талбайн төв хэсэгт болон тухайн газар ашиглалтыг бүрэн төлөөлөхүйц байх.

5.3.2. Мониторингийн цэг нь орчны нөлөөлөлд автахгүй газарзүйн байрлалтай байх. Авто зам, худаг уст цэг, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газраас 50 метрээс дээш, өвөлжөө хаваржааны газраас 500 метрээс дээш зйтай байх. Шороон нэг салаа замын хувьд хажуугийн 5 метр зурvas, сум, аймаг хооронд холбосон замаас 150 метр зурvas, улсын чанартай авто замын хажуугийн зурвасаас 500 метр зайд төлөвлөнө. Энэ зайд нь хот, тосгон, бусад суурины мониторингийн цэгт хамаarahгүй.

5.3.3. Уурхайн эдэлбэрийн газраас бусад тохиолдолд уул уурхайн ашиглалт бүхий олборлолт, ашиглалтын талбайгаас 5 км-ээс дээш зайд байх бөгөөд уурхайн гаднах дэд бүтэц дагуу, салхин доор газарт төлөвлөхөөс татгалзах.

5.4. Бэлчээрийн газрын фото мониторингийн цэг шинээр төлөвлөхдөө энэхүү аргачлалын 5.2.1 дэх зарчмыг баримтлах ба газар дээр нь байршлыг тогтоохын өмнө дараах тусгайлсан шалгуурыг шалгана.

5.4.1. Хиймэл дагуулын мэдээнд урьдчилсан боловсруулалт хийх:

-Ургамлын нормчлогдсон ялгаврын индекс (NDVI)-ийг бодуулж ойролцоо утгаар нь ангилан төлөөлөх цэгийг сонгоно. Мөн хөрсний элэгдэл, салхины нөлөөгөөр хөрс элэгдэх хэмжээ зэргийг газар зүйн мэдээллийн системийн программ хангамж ашиглан (RUSLE, WEQ) загварыг ажиллуулж элэгдэл эвдрэлд ороогүй газруудад төлөөлөх цэгийг сонгоно.

5.4.2. Газар ашиглалтын төлөвлөлтөд ороогүй газарт сонгох. Тариалангийн болон газар өмчлөлийн шинэ суурьшлын бүсэд ороогүй газар байна.

5.4.3. Бартаа саадгүй газарт цэг байгуулах. Гуу жалга, уулын хадтай орой, хиргисүүр, тайгын голд, намгийн дунд, голын арал, цөлийн болон элс, явар зэрэг бартаа саадтай, авто тээвэр хүрэх боломжгүй газар сонгохгүй.

5.5.4. Тусгай хэрэгцээний газар болон отрын бүс, хадлангийн талбай төлөөлөх ажиглалтын талбар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газрын 10%-аас дээш газрыг хамарч байгаа тохиолдолд бэлчээрийн фото мониторингийн цэгийг сонгоно.

5.6. Дараах нөхцөл тогтоогдвол газрын мониторингийн цэгийг төлөвлөхгүй.

5.6.1. Тухайн ажиглалтын талбараас эрс ялгараах газрууд болох тарваганы дош, малын хуучин хот, авто тээврийн хуучин зогсоол, геологийн хайгуул хийж орхигдсон газар, эртний балгадын туурь зэрэгт цэг сонгох төлөвлөж, сонгохгүй.

5.6.2 Гуу жалга, үер ус, хатуу урсац зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөлөлд байнга автдаг, эсвэл орохоор нөхцөлтэй газарзүйн байрлалд цэг төлөвлөж, сонгохгүй.

**Зургаа. Газрын мониторингийн цэгийг шинээр төлөвлөх үйл ажиллагааг үнэлэх**

6.1 Газрын мониторингийн цэгийг төлөвлөх үйл ажиллагааг үнэлэхдээ ажиглалтын талбарын болон цэгийн шалгууруудыг нэгтгэсэн хүснэгтэд оруулж, эцсийн үр дүнг гаргана.

6.2 Үнэлгээний матриц онолын хувьд бүгд шалгуурыг хангасан дээрх хүснэгт хэлбэртэй байх нь сайн боловч ямар нэг хүндрэл тохиолдвол дараах дүрмийг мөрдөнө.

6.2.1 Мониторингийн ажиглалтын талбар сонгох заавал мөрдөх шалгуурыг нэг бүрчлэн хангана (1. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх, 2. газар ашиглалтыг төлөөлөх, 3. ургамлан нэмрэгийг төлөөлөх, 4. судалгаа шинжилгээ хийхээр очиход хүндрэл багатай байх, 5. хөрсөн бүрхэвчийг төлөөлөх, 6. холбогдох төлөвлөлтүүдтэй уялдах);

6.2.2 Харгалзан үзэх шалгуурын дор хаяж 2 үзүүлэлтийг биелүүлэх (1. талбайн хувьд хангалттай байх, 2. доройтолд ороогүй байх эсвэл газрын доройтлын төрлийг төлөөлөхүйц, 3. суурь мэдээлэл бүрдсэн байх, 4. төлөвлөгөөт хянан баталгаанд хамрагдсан байх, 5. газрын гадаргуугийн хэлбэрийг төлөөлөх)

6.2.3 Мониторингийн цэгийн байршлыг сонгох шалгууруудыг нэг бүрчлэн биелүүлсэн байх хэрэгтэй бөгөөд фото мониторингийн цэг нь ургамлан нэмрэгийг төлөөлөх, судалгаа шинжилгээ хийхээр очиход хүндрэл багатай байх, хөрсөн бүрхэвчийг төлөөлөх шалгуурыг заавал биелүүлнэ.

Хүснэгт 4. Мониторингийн цэгийг өтгөрүүлэх, нэмж байгуулах шалгуур.

№	Шалгуур	Шалгуурыг хангаж байвал 1 оноо, хангахгүй байвал 0 оноо
Мониторингийн ажиглалтын талбар сонгох заавал мөрдөх шалгуур		
1.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх	
2.	Газар ашиглалтыг төлөөлөх	
3.	Ургамлан нэмрэгийг төлөөлөх	

4.	Судалгаа шинжилгээ хийхээр очиход хүндрэл багатай байх	
5.	Хөрсөн бүрхэвчийг төлөөлөх	
6.	Холбогдох төлөвлөлтүүдтэй уялдах	
<b>Харгалзан үзэх шалгуур</b>		
1.	Талбайн хувьд хангалттай байх	
2.	Доройтолд ороогүй байх эсвэл газрын доройтлын төрлийг төлөөлөхүйц	
3.	Суурь мэдээлэл бүрдсэн байх	
4.	Төлөвлөгөөт хянан баталгаанд хамрагдсан байх	
5.	Газрын гадаргуугийн хэлбэрийг төлөөлөх	

**Жич:** Заавал мөрдөх шалгуураас 6 оноо авсан тохиолдолд харгалзан үзэх шалгуурыг үнэлнэ. Заавал мөрдөх шалгуур, харгалзан үзэх шалгуурын нийлбэр оноо нь 8-аас дээш тохиолдолд тухайн газрын мониторингийн цэгийг нэмж байгуулна.

- --000-- -